

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

**ХЯТАДЫН ХӨРӨНГӨТӨН—ГАЗРЫН ЭЗДИЙН БҮГД
НАЙРАМДАХ УЛС (1911--1949)**

Н. Ишжамц, ШУА-ийн сурвалжлагч гишүүн

XX зууны эхээр Хятад орон нь империализмын хагас колони болж, капиталист зах зээлийн хүрээнд улам улмаар татагдан орж байсан юм. Хятадад ноёлж байсан Манж Чин улсын феодалын төр нь империалист гүрнүүдийн түрэмгийллийн өмнө буулт хийж, тэдний хүчинд түшиглэн ноёрхлоо бэхжүүлэх нэн харгис бодлого явуулж байв. Өвөр хоорондоо сүлбэлдэн хуйвалдсан гадаадын империализм, харь Манжийн төр хоёрын давхар дарлал Хятадын ард түмний нуруун дээр нүсэр дарамт болж, өдөр тутам байдлыг улмаар хүндрүүлэн хурцатгаж байв.

Хятад орныг тийнхүү империализмын хагас колони болгож, хөрөнгөтөн гүрнүүдийн өмнө өр ширэнд оруулан, үндэсний хөгжлийг боогдуулан байсан дотоодын гол хүчин зүйл буюу гэмтэн нь Манж Чин улсын ноёрхол байсан юм. Хувьсгалт хүчин, нийт ард түмний тэмцэлийн хурц үзүүр нь түрүү Манжийн төр, Чин улсын ноёрхлын эсрэг хандаж байжээ. Манж Чин гүрний дотор капитализм нэвтрэн хөгжиж эхлэхийн хамт Хятад, Монгол, Төвд зэрэг оронд бас үндэстэн үүсэн бүрэлдүүлэх үйл явц эхэлж, үндэстэн угсаатан тус бүрийн дотор Манжийн ноёрхол, империалист колоничлол, Хятадын хөрөнгөтөн, газрын эздийн дарлалын эсрэг хандсан, бүх нийтийн шинжтэй үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөжээ. Ялангуяа Оросын 1905—1907 оны хувьсгалын нөлөөгөөр Ази тивийн олон үндэстэн угсаатан улс төрийн талаар сэрэн босохын хамт хятадын ард түмэн бас төрийн тусгаар тогтнолоо сэргээн, эрх чөлөөг байлдан олохын төлөө хувьсгалт тэмцэл өрнүүлсэн байна. Тэр тэмцлийг удирдан зохион байгуулахад Хятадын нэрт ардчилсан хувьсгалч, доктор Сүнь Ятсен ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Сүнь Ятсен Хятадын хөрөнгөтний ардчилсан хувьсгалын онол, үзэл суртал, улс төрийн үндэс болсон «ардын гурван зарчим» хэмээх баримтлалыг боловсруулан гаргасан байна. Тэр гурван зарчмын 1-р нь Манжийн ноёрхлыг устгаж, империализмын хагас колоничлолоос чөлөөлөгдсөн Хятадын үндэсний төр улсыг сэргээн байгуулах зорилго бүхий дэвшилт, эх оронч ёсны «үндэсний үзэл» байв. 2-р нь хаант засгийг устгаж, бүгд найрамдах улс байгуулах гэсэн «ардын эрхт засаг»-ийн баримтлал байв. 3-р нь «ард түмний сайн сайхан» хэмээх ёс, тухайлбал газрын эздээс орлогын хэмжээгээр өсөн нэмэгдэх алба татах журмаар тарианы газрыг аажимдаа улсын өмч болгож, тариалангийн талбайг тариачны эзэмшил болгох зорилт байжээ. Сүнь Ятсен 1905 оны зун Японд байхдаа Токио хотноо тэрхүү

гурван зарчим дээр үндэслэсэн Хятадын хөрөнгөтний ардчилсан үзэлтэн нар, хөрөнгөтөн газрын эздийн зарим төлөөлөгчдийг оролцуулсан «Хятадын хувьсгалт нэгдмэл холбоо» хэмээх улс төрийн намын шинж чанартай байгууллагыг үүсгэн байгуулсан байна.¹ «Хятадын хувьсгалт нэгдмэл холбооны» гол сэтгүүл «Миньбао» (Ардын сонин) нь үндэсний ардчилсан хувьсгалын зорилтыг сурталчилж, олон түмнийг тэмцэлд уриалж байв. Хувьсгалчдын олонхи нь зөвхөн Манжийн ноёрхлыг түлхэн унагаад зогсохгүй, империалист колоничлогчдыг хөөн зайлуулж, тэдний эрхшээл нөлөөнөөс бүрмөсөн чөлөөлөгдөх тухай асуудал тавьж байв. Тэд «Гадаадын чөтгөрүүдийг хядан устгая!»² гэсэн лоозон дэвшүүлж байв. Хувьсгалчдийн эгнээнд багтаж байсан зарим этгээдийн зүгээс Хятад орон бол «Асар олон хүний нөөцтэй тул хүчин чадлын онцгой сурвалж юм», тийм учир «хэдэн сая юм уу хэд арван сая хүний амь үрэгдсэн ч гэсэн гайгүй хэрэг, эх орноо аварсан цагт хэдэн арван жилийн дараа хүн амын дутуу нь дахин нөхөгдөнө» гэсэн адал балмад уриа тарааж, цөөн заримынх нь амнаас гагцхүү Хятад орон л Европ, Америкийн «цагаан арьстны аюулын» эсрэг Азийн бүх «шар арьстан» улс түмнийг нэгтгэн тэмцэж чадна гэсэн үндсэрхэг дээрэнгүй үзэл, арьсны онолын үг цухалзуулж байжээ.³

1911 оны 1-р сарын 10-ны орой төв Хятадын Хүбэй мужийн Учан хотод «Нэгдмэл холбоотой» байнгын харилцаа тогтоож, удирдамж заавар авч байсан орчин цагийн маягийн шинэ цэргүүд Манж Чин улсын ноёрхлын эсрэг зэвсэгт бослого гаргаад, түүнд зэргэлдээх Ханьян, Ханькоу хотын цэрэг иргэд нийлэн нэгдэж хувьсгал эхэлсэн байна. Дээрх гурван хотын хувьсгалчид, мужийн зөвлөлдөх хорооны хамтарсан хуралдаанаас Манжийн ноёрхлыг эцэс болгож, Чин гүрний ор суурин дээр Хятад, Манж, Монгол, Хотон, Төвд таван угсааны хүн ард нэгэн улс гэрийн дотор нийлэн нэгдсэн, бүгд найрамдах засагт Хятад улсыг тэрлэн байгуулах шийдвэр гаргасан байна. Удалгүй Манжийн төрийн нийслэлж байсан Бээжин орчмын Чжили (Хэбэй), Хэнань болон Ганьсу мужаас бусад бүх 15 муж нь 10, 11-р сард тус тусын манж захиргааг халж, Бээжингээс тусгаарлан салж, шинэ байгуулагдах төрд дагах тухай албан ёсоор илэрхийлсэн байна.

1912 оны 1-р сарын 1-ний өдөр Төв Хятадын Нанкин хотод нийслэлсэн «Дундад иргэн улс» хэмээх хөрөнгөтөн газрын эздийн бүгд найрамдах улс байгуулагдаж, Сүн Ятсен түүний анхны ерөнхийлөгчөөр түр хугацаатай сонгогдсон байна. Хятадын хөрөнгөтний хувьсгалчид, бүгд найрамдах улсын удирдлагын дотроос Сүн Ятсен тэргүүтэй нэгэн хэсэг ардчилсан хувьсгалч нар эх оронч үзэл, ардчилал, ард түмний аж байдлыг дээшлүүлэх тухай «ардын гурван зарчмыг» нэлээд тууштай хэрэгжүүлж, хувьсгалыг бүрэн ялалтанд хүргэхийг зорьж байв. Тэд Манжийн төрийг бүр мөсөн устгаж, Бээжин ба умард Хятадын бусад нутгийг чөлөөлж, феодалын ёсыг халж, империализмын хагас колоничлолын дэглэмийг устгах зорилт тавьж байв. Гэтэл тэр нь дотоод, гадаадын ноцтой саад бэрхшээлтэй тулгарсан байна.

Хятадын хувьсгалын анхны гараа зарим ялалт хийж, бүгд найрамдах засаг тунхаглан Нанкины засгийн газар нэгэнт байгуулаад

1. Всемирная история, т. УП, М., 1960, с. 261.
2. История Китая с древнейших времен до наших дней, под редакцией Л. В. Симоновской и М. Ф. Юрьева, М., 1974, с. 235.
3. Мөн тэнд.

байсан 1912 оны эхээр ч гэсэн Бээжинд Манжийн хаан, Чин улсын засгийн газар урьдын адил оршин тогтносоор байсан бөгөөд хувьсгалыг дарж, бүгд найрамдах засгийг цуцлахын тулд дотоод, гадаадын харгис хүчнүүдийг талдаа татаж, ил далд эвсэл холбоо байгуулж байв. Тэр зорилгоор хуучин Манжийн төрийн эрх баригчид империалист гүрнүүдтэй сэм хуйвалдан генарал Юань Шикай гэгчийг ерөнхий сайд, бүх цэргийн жанжин болгож, мөнгө хөрөнгө, цэрэг зэвсгээр ханган Нанкины эсрэг тавьсан байна. Юань Шикай бол либерал хөрөнгөтөн—газрын эздийн бие төлөөлөгч, Ли Хүнчжаны үндэслэсэн Бэйяны бүлгийн томоохон феодалын цэргийн эрхтний нэг байсан тул тэр бодлогод идэвхтэй оролцож, империализм, феодализм, Манжийн төрийн дэмжлэг тусламжтайгаар Нанкины засгийн газар, түүний харьяанд орсон муж, хотуудын харгис хүчинтэй холбоо сүлбээ тогтоож, хувьсгал ба бүгд найрамдах засгийг дотроос нь задлан бутаргах хорт явууллага хийсэн байна. Либерал хөрөнгөтөн, газрын эздийн төлөөлөгчид хувьсгал гүнзгийрч, ард түмэн идэвхжихээс болгоомжлон, ангийн ашиг сонирхлоо гол болгож хувьсгалчдаас хөндийрч байсан бөгөөд жинхэнэ хувьсгалч нарын олонхи нь харгис хүчний тэмцэлд амь үрэгдэж бусад хувьсгалч нар нь ард түмнийг хувьсгалд өргөн хэмжээгээр татан оруулж, түүнд түшиглэх бодлого тууштай явуулаагүй зэргийн учир хувьсгалын явц хүнд байдалд оржээ. Тийм нөхцөлд 1912 оны 12-ны өдөр Манжийн хааныг төрийн эрхнээс бүрмөсөн огцруулж, хаант засгийг устгаад дараа өдөр нь Сүн Ятсен ерөнхийлөгчийн албан тушаалыг Юань Шикайд шилжүүлэхэд хүрсэн байна. Юань Шикай Манжийн сүүлчийн хааныг Бээжин дахь өвөл, зуны хуучин ордон харшид нь ихээхэн эрх ямбатайгаар үлдээж, жилийн 4 сая лан мөнгөний байнгын хангамжийг улсын сангаас олгож байх болгосон байна.

«Нэгдмэл холбооны» гишүүн байсан хөрөнгөтний хэсэг хувьсгалчид либерал хөрөнгөтний зарим байгууллагатай нийлж 1912 оны 8-р сард Хятад үндэстний гоминдан намыг байгуулжээ. Гэвч түүний улс төрийн мөрийн хөтөлбөрт нь Сүн Ятсений «ардын гурван зарчмын» гуравдахыг оруулаагүй хассан байна. Энэ бол либерал нарыг дагалдан үндэсний хөрөнгөтнүүд хувьсгалын үйл хэргээс ухарч эхэлсэн хэрэг байв.

Юань Шикай 1913 онд хувьсгалыг цэрэг зэвсгийн хүчээр дарсан юм.

Сүн Ятсен тэргүүтэй хувьсгалчид гадаадад цагаачлан гарахад хүрээд Хятадад либерал хөрөнгөтөн—газрын эздийн ноёрхол бэхжиж, түүний гол төлөөлөгч Юань Шикай тэргүүтэй цэргийн эрхтний диктатур тогтжээ.

Дэлхийн I дайны үед Хятадын засгийн газар империалист гүрнүүдийн аль ч талын эвсэлд үл оролцох тухай зарлаж, Хятад нутагт байлдааны үйл ажиллагааг шилжүүлэхгүй байхыг тэдэнд уриалсан боловч 1914 оны 8-р сард Япон нь Хятадын Шаньдүн муж дахь Германы колони Циндао хойгийг эзэлж, 1915 онд Хятадад түрэмгийлэн эзлэх шинжтэй «21 зүйлийн шаардлага» тулгасан байна. Тэдгээр шаардлага ёсоор Япон нь Шаньдүн мужийг Хятадаас бүрмөсөн таслан авч, Манжуур болон мөн Өвөр Монголын зүүн хэсгийг хяналтандаа оруулж, аажмаар нийт Хятадад ноёрхлоо тогтоох явдал байв. Хятадын ард түмэн үүнийг эрс эсэргүүцэж байсан боловч Юань Шикай Японд буулт хийж, 1915 оны 5-р сард уг шаардлагыг хүлээн авах хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

1916 онд Юань Шикай биеэ эзэн хаан гэж өргөмжилж, Хятадад хаант засгийг сэргээх гэж байгаад гэнэт нас барж, түүний харгис-

лал, хэнээрхэл эцэс болсон байна. Хятад улс нь Манжуурын хунхууз дээрэмчдийн бүлгийн зонхилгогч Чжан Цзолин тэргүүтэй Мүгдэн—Фэнь—тяний цэргийн эрхтний бүлэглэл, Фэн Гочжан тэргүүтэй Чжилийн цэргийн эрхтний бүлэглэл, Дуань Цижүй тэргүүтэй Аньхой мужийн Аньфу намын цэргийн эрхтний бүлэглэл, Юньнань, Гуанси мужийн цэргийн эрхтний бүлэглэл зэрэг олон тооны феодал—цэргийн эрхтний бүлэглэлд хуваагдсан байна. Цэргийн эрхтний тийм бүлэглэл тус бүр ямар нэгэн империалист гүрнийг түшиглэж, түүний гар хөл болж, улс орны дотоод, гадаад байдлыг ноцтой хүндрүүлж байв.

1917 онд Октябрийн социалист их хувьсгал ялж, Зөвлөлт Орос улс байгуулагдсан явдал Хятад орны цаашдын амьдрал хөгжилд ихээхэн чухал нөлөө үзүүлсэн юм.¹ Хятадын хувьсгалчид болон ард түмэн Октябрийн хувьсгалыг үнэн сэтгэлээсээ талархан дэмжиж, Оросын ард түмний замнасан цоо шинэ замаар замнаж эрх чөлөөнд хүрч болохыг ойлгосон байна. 1918 онд Хятадын тэргүүний сэхээтэн нарын төлөөлөгч, Бээжингийн их сургуулийн профессор Ли Дачжао сонин, сэтгүүлд Октябрийн хувьсгалын тухай хэд хэдэн өгүүлэл бичиж, «Одоогоос эхлэн дэлхий дахин хөдөлмөрчдийн ертөнц болж байна» гэж цохон тэмдэглэж байжээ.² Сүнь Ятсен Зөвлөлт засгийн газар түүний тэргүүн В. И. Ленинд цахилгаан утас илгээж, баяр хүргээд «Орос, Хятадын хувьсгалт намууд хүчээ нэгтгэн хамтын тэмцэл хийнэ»³ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлсэн байна.

1919 оны 5-р сарын 4-нд Бээжингийн их сургуулийн оюутнууд сүрт жагсаал хийж, Шаньдүн мужаас Японы эзэрхэг түрэмгий нарыг хөөн зайлуулах, империализмын колоничлолыг эсэргүүцэх, эх орноос урван тэрсэлж Японы талыг баримталсан Дуань Цижүй нарын зэрэг Аньфу намын бүлгийнхнийг засгийн эрхнээс зайлуулах шаардлага тавьж, эх оронч хөдөлгөөн өрнүүлсэн байна. 5-р сарын турш үргэлжилсэн тэр хөдөлгөөнд Шанхай, Нанкин зэрэг томоохон хотын ажилчид Японы мэдлийн үйлдвэрүүд дээр ажил хаях, бараа таваарыг нь худалдан авахаас татгалзах зэргээр оролцож, Хятадын пролетари нар анх удаа улс төрийн тавцан дээр идэвхтэй тэмцэлд гарч ирсэн байна.

1921 оны 7-р сарын 1-нд Хятадын Коммунист намын анхдугаар их хурал хуралдаж ХКН байгуулагдсан юм. Тухайн үед ХКН-ыг Чень Дүсю толгойлж байсан бөгөөд намын эгнээнд Ли Дачжао, Дэн Чжунся, Цюй Цюбо, Чжан Тайлэй, Пэн Бай нарын зэрэг тууштай коммунистууд багтаж байжээ. Тэд Коминтернтэй холбоо барьж, түний санал зөвлөгөөг хүлээн авч, гадаадын империализм, дотоод дахь феодализм ба цэргийн эрхтэн нарын эсрэг үндэсний нэгдсэн фронт байгуулж тэмцэх, тэхдээ нам ба ажилчин ангийн биеэ даасан байдлыг эрхэмлэх бодлого явуулж байжээ. Гэвч ХКН-ын удирдлага нь ардчилсан төвлөн удирдах ёсны зарчмыг цалгардуулж, үндэстний цөөнхийн хувьд орон нутгийн автономит эрхийн бодлого баримталж, өөртөө засан тохинох эрх олгохоос татгалзаж байжээ. Энэ нь цаашдаа Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн нэгдмэл үйл ажиллагаа, ялангуяа үндэстний цөөнхүүдийн дунд хувьсгалт хөдөлгөөн өрнөхөд муу нөлөө үзүүлж байв.

Хэдий тийм боловч 20-иод оны эхнээс Хятадын бүгд найрамдах улсын үндсэн Хятад нутгуудад, ялангуяа Өмнөд Хятадын хот, хөдөөд хагас колонийн байдал, заримдаг феодалын ёсны эсрэг хувьсгалт тэмцэл улам улмаар өрнөж байв. Түүнд ажилчин, тариачин нараас

1. Хятадын хураангуй түүх, Бээжин, 1981, 511-р тал. (хятадаар)
2. История Китая с древнейших времен . . . , с. 257.
3. Мөн тэнд.

гадна үндэсний хөрөнгөтөн татагдан орж байв. 1923 онд Сүнь Ятсен Гуанчжоу дахь Өмнөд Хятадын бүгд найрамдах засгийг дахин толгойлж, улмаар Зөвлөлт Оростой холбоо байгуулж, ХКН-тай хамтарч ажиллаад ажилчин, тариачдыг дэмжин туслах улс төрийн бодлого явуулсан байна. Тэрээр Зөвлөлтөөс алдарт жанжин В. К. Блюхер нарын зэрэг зөвлөгч, мэргэжилтэн нарыг урьж туслуулж байсан бөгөөд Хуанпүд орчин үеийн маягийн цэргийн сургууль байгуулж, үндэсний хувьсгалт цэргийн эх үндсийг тавьсан байна. 1924 онд Английн империализмын хатгалга түлхээсээр Гуанчжоуд хувьсгалын эсэргүү самуун дэгдсэнийг тэрхүү хувьсгалт цэрэг, ажилчны отрядууд хамтын хүчээр дарсан байна. 1925 оны гуравдугаар сард Сүнь Ятсен нас барсан боловч үхэхийнхээ өмнө өөрийн толгойлж байсан Гоминдан намд эрх чөлөөний төлөө тэмцлийг тууштай үргэлжлүүлэх, ЗХУ ба коммунист намтай найрамдлыг бэхжүүлэх тухай тусгай гэрээслэн бичиж үлдээсэн байна. Сүнь Ятсен Зөвлөлтийн засгийн газарт илгээлт бичиж, Хятад, Зөвлөлт «хоёр орон дарлагдсан үндэстнүүдийн эрх чөлөөний төлөө их тэмцэлд гар гараасаа барилцан урагшилж ялалтанд хүрсэн үед хүчирхэг бөгөөд эрх чөлөөт Хятадыг ЗХУ шилдэг найзын хувьд баяр хүргэн мэндчилэх цаг ирнэ»¹ гэдэгт итгэн найдаж байгаагаа илэрхийлсэн байна.

Зөвлөлт засгийн газар нь Гуанчжоугийн засгийн газрын хувьсгалт үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Бээжингийн засгийн газартай хэвийн харилцаа тогтоох бодлого явуулсны ачаар 1924 оны 5-р сард Зөвлөлт, Хятадын харилцааны ерөнхий зарчмын тухай хэлэлцээр байгуулагдаж дипломат харилцаа тогтсон байна.²

1925 оны 5-р сарын 30-ны өдөр Шанхай хотын ажилчид, оюутан сурагчид Японы мэдлийн үйлдвэрүүд дээр ажил хаяж, бараа таваарыг нь худалдан авахаас эрс татгалзан империализм, феодализмыг эсэргүүцсэн хөрөнгөтний ардчилсан хувьсгалыг эхэлсэн байна.³ Өмнөд ба Төв Хятад даяар ажилчид, тариачид, оюутан сэхээтэн, үндэсний хөрөнгөтөн оролцож, коммунистуудын удирдсан бослого хөдөлгөөн, ажил хаялт өрнөж 1927 оныг хувьсгал үргэлжилсэн юм. Хувьсгалчид Гуанчжоу, Шанхай, Нанкин, Ухань зэрэг хот тосгоныг чөлөөлжээ. Хятадын 1925-1927 оны хувьсгалыг ЗХУ, Коминтерн болон дэлхий бусад бүх хувьсгалт, дэвшилт ардчилсан хүчин талархан дэмжиж байв. Гэтэл 1927 оны 4-сард гоминдан намын баруун жигүүрийн Чан Кайши тэргүүтэй үндэсний хөрөнгөтний төлөөлөгчид хувьсгалаас урван тэрсэлж, империалистуудтай сүлбэлдэн, Шанхай, Нанкин зэрэг хотуудад хувьсгалын эсэргүү эргэлт хийж, цаашдаа хувьсгалыг цэрэг зэвсгийн хүчээр дарсан байна. Коммунист намын удирдлагын Чэнь Дүсюэ нарын зэрэг зарим хүмүүс барууны үзэл баримтлан, Гоминданд буулт хийж, хүлээн харж суух мэтийн алдаа гаргасан явдал хувьсгал дарагдах явдалд тус дөхөм болжээ.

Нанкин дахь Чан Кайши тэргүүтэй Гоминданы засгийн газар нь Зөвлөлтийн эсрэг бодлого явуулж, 1929 онд Хятад, Зөвлөлтийн хамтын хоршмол ажиллагаатай дорнод хятадын төмөр зам буюу Маньчжуурийн төмөр замын гол шугамыг дайран эзэлж, тэнд ажиллаж байсан зөвлөлтийн хэдэн мянган мэргэжилтэн, ажилчдыг барьж хорьсон байна. Гоминданыхан зөвлөлтийн элчин сайдын яам, дипломат төлөөлөгчдийн газрыг элдвээр хяхан хавчиж, хэвийн байдалтай ажиллах боломжгүй болгож байв. Гоминданы засгийн газар, түүний

1. История Китая с древнейших времен . . . , с. 281.
2. Всемирная История, т. IX, М., 1962, с. 112.
3. Новейшая история Китая. (1917-1927), М., 1983, с. 209

тэргүүн Чан Кайши нь БНМАУ-ын тусгаар тогтнолд заналхийлж, Монголын хувьд түрэмгийлэн эзлэх, өдөөн хатгалын бодлого явуулж байв.

Хувьсгал дарагдсаны дараа хувьсгалд үнэнч хэвээр үлдсэн үндэсний хувьсгалт цэрэг бослогын цэргийн анги багууд нь Төв ба Өмнөд Хятадын янз бүрийн муж, районуудад ажилчин, тариачны төлөөлөгчидийн зөвлөлүүд байгуулж, тэмцлийг үргэлжлүүлж байв. 1927 оны 11-р сард Гуандун мужид Хайлуфыны зөвлөлт бүгд найрамдах улс тунхаглагдсан боловч дараа жил нь гоминданд цохигдон мөхжээ. Гэвч 1928—1930 оны туршид Хятадын 11 мужид 11 мужид 15 зөвлөлт район байгуулагдаад байв. 1931 оны 11-р сарын 7-нд Хятадын Зөвлөлт районуудын төвийн Жүйцзин хотод зөвлөлүүдийн анхдугаар их хурал хуралдаж, Хятадын зөвлөлт бүгд найрамдах улсыг байгуулан тунхаглажээ. Гэвч Хятадын зөвлөлт засаг хараахан бэхжээгүй, зөвлөлт районууд болон хувьсгалт цэргийн ангиудын үйл ажиллагаа нь орон нутгийн шинжтэй байв.

1931 оны 9-р сард Японы эзэрхэг түрэмгийчүүд Хятадын зүүн хойт хэсэг буюу Манжуур, Өвөр Монголын зүүн хэсгийг эзэлж, Манжийн сүүлчийн хаан байсан этгээдийг урвуулан хулгайлж аваачаад 1932 онд тэнд «Манж—го» гэгч тоглоомын улсын засгийн газрыг байгуулжээ. Япончууд 1933—1935 оны хооронд Умард Хятадын Жэхэ муж, Өвөр Монголын цахарын чуулганыг эзлэн авчээ. ЗХУ Японы түрэмгийллийг шийдвэртэй эсэргүүцэж, Хятадын ард түмний тэмцлийг тууштай дэмжиж байсан юм. Гэтэл АНУ болон Баруун Европын империалист гүрнүүд зөвлөлтийн эсрэг балмад явууллагадаа Японыг татан оруулж ашиглахын тул Хятадыг дэмжихгүй байв. Хятадын гадаад, дотоод байдал улам бүр хүндэрч, харийн түрэмгийлэлд эрсдэх аюул ихэссээр байв.

Энэ хооронд 1933—1934 оны үест гоминданы засгийн газар нь Японы түрэмгийллийн эсрэг тэмцэхийн оронд Өмнөд Хятадын Зөвлөлт районуудын эсрэг их цэрэг хэдхэдэн удаа хөдөлгөж, байдлыг ихэд хүндрүүлжээ. 1934 онд тэдгээр районы хувьсгалт цэрэг умард зүг нутаг шилжих их аялал эхэлсэн байна. Их аялалын явцад 1935 оны эхээр Гуйчжоу мужийн Цзүньи хотод ХКН-ын Төв Хорооны улс төрийн товчооны өргөтгөсөн зөвлөлгөөн болох үеэр жижиг хөрөнгөтний «зүүнтний» маягийн хэт гаармал хувсгалчдын нэг, үндэсний дээрэнгүй үзэлтэн Мао Цзэдүн төв хорооны удирдлагыг гартаа авчээ. Гэвч 1935 оны эцэс, 1936 оны эхээр Хятадын хувьсгалт цэргийн умардын их аялал зорьсон газартаа хүрч, Шэньси, Ганьсү, Нинся мужуудад Хятадын зөвлөлт шинэ район байгуулж, Яньань хотод төвлөрөн Японы түрэмгийллийн эсрэг тэмцэл явуулжээ.

ХКН нь 1935 онд хуралдсан Коминтерний VII их хурлын шийдвэр ёсоор Японы түрэмгийллийн эсрэг улс орны дотоодын бүх нам, бүлгүүдийн хүчийг нэгтгэсэн үндэсний нэгдсэн фронт байгуулах бодлого явуулж байв. Гоминданы нам түүнийг удтал зөвшөөрөхгүй байсан боловч 1937 оны зун Японы цэрэг Бээжин, Тяньцзин, Шанхай зэрэг томоохон хотуудыг эзэлж, Нанкины засгийн газар аюулд учрах болсны дараа коммунистуудын саналыг хүлээн авахаас өөр аргагүй болжээ. Мөн оны намар ХКН биеэ даасан байдлыг алдалгүйгээр гоминданы бүрэлдүүнд орж, Чжү Дэгийн командалсан хувьсгалт цэрэг Хятадын бүгд найрамдах улсын цэргийн наймдугаар арми болж, Японы түрэмгийллийн эсрэг үндэсний нэгдсэн фронт байгуулагдсан байна.

ХКН-ын шууд удирдлагын дор ажиллаж байсан VIII арми ба шинээр байгуулагдсан IV арми нь Японд эзлэгдсэн мужуудад парти-

зан отрядуудыг байгуулан тэмцэж, дайсны ар талд шинэ шинэ чөлөөлөгдсөн районуудийг бий болгож байв. Гэвч дэлхийн II дайны үед Японы империализм, гоминданыхан аль аль нь чөлөөлөгдсөн районы эсрэг их цэрэг давшуулан байлдуулж байсан учир тэдгээр районы байдал ихэд хүндэрсэн байв. Чухам тэр үед Мао Цзэдүн «үзэл суртал цэгцлэх хөдөлгөөн өрнүүлэх» нэрийдлээр олон тооны интернационалч коммунистуудыг хэлмэгдүүлж, намын үзэл сурталд марксизм—ленинизмийг өөрийн үндсэрхэг дээрэнгүй үзлээр солих оролдлого хийж байжээ. 1945 оны 4, 6-р сард ХКН-ын YII их хурал хуралдаж «Мао Цзэдүний үзэл санаа» гэгчийг марксизм—ленинизмтэй зэрэгцүүлэн тавьж «намын үйл ажиллагааны удирдлага болгоно» хэмээн зарласан юм.

Дэлхийн II дайнд Зөвлөлтийн Арми Германы фашизм, Японы милитаризмыг бут цохиж, Монгол цэргийн хамт Зүүн хойд Хятад Өвөр Монголыг чөлөөлсөн нь Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн үйл хэрэгт үндсэн эргэлт гаргасан юм. Ялангуяа аж үйлдвэрийн талаар Хятаддаа тэргүүн зэргийн хөгжилтэй Зүүн хойд Хятад нь хүчирхэг хувьсгалт бааз болж, түүнийг тууштай интернационалч коммунистууд толгойлж байсан явдал Хятадын хувьсгалын цаашдын өрнөлт, ялалтад маш чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Японы милитаризмыг бутцохисны дараа гоминданы ноёрхолд үлдсэн Хятадын ихэнх нутагт америкийн империализм эрхшээл нөлөөгөө хүчтэй нэвтрүүлж, нийт Хятадыг колоничлох оролдлого хийсээр байв. Гэвч ЗХУ асар их хүч нөлөөтэй болж, Европ ба Азийн хэд хэдэн орон социализмын замд орж, олон улсын хүчний харьцаа социализмд ашигтайгаар өөрчлөгдсөн II дайны дараах үеийн нөхцөлд Хятадын ард түмэн гадаадын империализм, дотоодын харгислалын нэн амжилттай хувьсгалт тэмцэл өрнүүлж, амжилт олох бололцоотой болжээ.

1946 оны 3-р сард гоминданы засгийн газар нь бүх цэргийн 80 хувийг чөлөөлөгдсөн районуудын эсрэг хөдөлгөж иргэний дайн эхэлсэн юм. Энэ нь Хятадын ард түмний дургүйцлийг ихэд хүргэж, хот, хөдөөд ажил хаях, сүрт жагсаал хийх зэрэг хүчтэй эсэргүүцэл тэмцэл өрнөхөд хүргэсэн юм. Өвөр Монгол, Сикан муж дахь төвд угсаатны районууд, Синьцзян, Тайваньд гоминданы эсрэг бослого хөдөлгөөн гарчээ. 1947 онд гоминданы намд хагарал гарч, дэвшилт зүүн жигүүр нь Чан Кайши тэргүүтэй харгис баруун жигүүрээс зааглан салж, ХКН-тай холбоо тогтоон дотоод, гадаадын харгис хүчний эсрэг тэмцэлд нийлсэн байна. Гоминданы ноёрхолын эсрэг тэмцэлд Өвөр Монголын ардын хувьсгалт нам, Өвөр Монголын хувьсгалчид болон хөдөрмөрчин ард түмэн идэвхтэй оролцож чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1920-иод оноос эхлэн Хятадын хөрөнгөтөн, газрын эздийн дарлалыг эсэргүүцэн боссон Өвөр Монголчуудын үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцэл нь дайны дараа ялалтанд хүрч, 1947 оны 5-р сарын 1-нд ардын хувьсгалт засагтай Өвөр Монголын өөртөө засах орон байгуулагджээ. Энэ нь цаашдаа Хятадын ард түмний хувьсгалт тэмцэл ялах явдалд чухал тус дөхөм болсон байна.

1948 оноос эхлэн Зүүн хойт Хятад дахь Хятадын ардын чөлөөлөх армийн анги нэгтгэлүүд сөрөг давшилтанд орж умард ба төв Хятадын олон хот тосгоныг гоминданы ноёрголоос чөлөөлжээ. 1949 оны 3-р сард ХКН-ын Төв Хорооны 2-р бүгд хурал хуралдаж, нийт орон даяар хувьсгалыг ялалтанд хүргэж, империализмын ноёрхол, гоминданы дарлалыг эцэс болгон, ардын засаг тогтоох шийдвэр гаргасан байна. Мөн оны 4-р сараас 9-р сар хүртлэх хугацаанд Хятадын ардын чөлөөлөх арми Өмнөд нутгийн дийлэнх ихэнхийг чөлөөлж, ингэснээр

1949 оны 10-р сарын эхээр империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал бүрэн ялсан байна.

Америкийн цэрэг Хятадад цөмрөн орохоос ЗХУ урьдчилан сэргийлсэн гадаад бодлого, дипломатын идэвхтэй үйл ажиллагаа явуулж, Хятадад ардын хувьсгал ялах явдалд ихээхэн чухал тусламж дэмжлэг үзүүлсэн юм.

БУРЖУАЗНО-ПОМЕЩИЧЬЯ КИТАЙСКАЯ РЕСПУБЛИКА (1911-1949)

(Резюме)

В статье даются краткий обзор и общая контура истории Китая когда в жуазно-помещичьи отношения и гоминьдановская диктатура.

В состав которой входил В начале XX в. Цинская империя, собственно Китай, оставалась страной полуколониальной и полуфеодальной. Ею правила все еще маньчжурская династия.

В 1911 г. в Китае произошла буржуазная революция, свергнувшая маньчжурское иго. В 1912 г. Китай превращается в буржуазно-помещичью республику. Сунь Ятсен был избран первым президентом у республики, но вскоре власть захватила либерально-помещичья клика, которая жестоко подавила революцию.

В 1921 г. была создана Коммунистическая партия Китая, а в 1925-1927 гг. вспыхнула там антиимпериалистическая буржуазно-демократическая революция. Китайский народ в своей революционной борьбе находит помощь и поддержку со стороны Советского Союза, однако сговор внешней и внутренней реакции, измена Чан Кайши и правого крыла гоминьдана сводят на нет первые успехи революционной борьбы. В стране устанавливается господство гоминьдановцев.

30-ые и первая половина 40-х годов характеризуются японской агрессией и установлением на значительной части страны фашистского режима. Гоминьдан проводит в значительной степени очень не решительную и даже капитулянтско-предательскую политику. КПК и китайский народ ведут героическую национально-освободительную борьбу, которая наносит сильный удар по врагам. Советский Союз, несмотря на трудность военного времени, оказывает братскую помощь китайскому народу, которая сыграла огромную роль в деле его освобождения.

В результате разгрома куантунской армии советскими войсками совместно с Монгольской Народно-революционной армией и освобождения Маньчжурии, Внутренней Монголии и части Северного Китая в 1945 г. создаются благоприятные условия для дальнейшего развертывания национально-освободительной борьбы. Несмотря на установившуюся частные военные походы гоминьдана многолетняя ление в Центральном и Южном Китае американского господства при освободительная борьба китайского народа увенчается успехом. Победа народной революции 1949 г. навсегда покончила с чужеземным гнетом и внутренней реакцией, положив начало социалистическому пути развития страны.